



ГУРВАНСАЙХАН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ДОЛГОР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.18

№

01 / 177

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлантгийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын Цэцэрлэгийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн ўйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 188,700.00 /Нэг зуун наян найман мянга долоон зуу/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. **Өөрийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан малыг төсвийн хөрөнгөөр худалдан авч мөнгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тушаасан, хөрөнгийн дансны бичилт хийлгүй үлдэгдлээр тайлагнасан байна.**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-т /*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/*, 3.1.1-т /*нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь*“ гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон уед, зардлыг гарсан уед нь хүлээн зөвшиөөрч бүртгэх аргыг/20.1.4-т /*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх/* заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн A/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /*Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/* заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх
2. Дансны бичилтийг санхүүгийн тайлант хугацаанд хууль журам, дансны бичилт хийх заавар журмын дагуу бүртгэж хэвших
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Гурвансайхан сумын Цэцэрлэгийн эрхлэгч /Х.Долгор/, нягтлан бодогч /Б.Энх-Амгалан/ нарт хариуцуулав.

199000712

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:


ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ



НЯГТЛАН БОДОГЧ

Х.ДОЛГОР

Б.ЭНХ-АМГАЛАН

¹ Акт, албан шаардлагын биөлэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биөлүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.